МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 09 өдөр Дугаар 1/406 Чойбалсан

# Түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 210 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Халхгол сумын төвийн төвлөрсөн халаалтын инженерийн шугам сүлжээний ашиглалтыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд бүрэн шинжилгээ хийх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 210 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Түншлэл төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ хийх журам”-ын дагуу зохион байгуулж, санал дүгнэлтийг 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөрт багтаан танилцуулж, тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бэлтгэл хангахыг хэсгийн дарга (Б.Саранчимэг)-д даалгасугай.

3.Ажлын хэсгийг удирдлага, арга зүйгээр бүрэн хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ЁЛ

My computer D/ Zakhiramj

2125010998

ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠡ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 60 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 60.1.1, ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 22 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 22.18, ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 13 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 13.2.1 ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠯᠠᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ 2024 ᠣᠨ ᠤ 210 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

1. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶᠢ ᠥᠷᠭᠡᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠳᠤ ᠵᠣᠷᠢᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠢᠯᠤᠨ ᠢ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠨ ᠰᠣᠨᠣᠰᠤᠭᠠᠳ ᠠᠩᠬᠠᠷᠤᠯ ᠳᠤ ᠪᠠᠢᠯᠭᠠᠪᠠ.

2. ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ 2024 ᠣᠨ ᠤ 210 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ 3 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠬᠠᠪᠰᠤᠷᠠᠯᠲᠠ ᠪᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ 《ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠢᠯᠤᠨ ᠤ ᠵᠠᠭᠪᠤᠷ》 ᠤᠨ ᠳᠠᠭᠠᠤ ᠪᠡᠯᠡᠳᠬᠡᠵᠦ, 2025 ᠣᠨ ᠤ 08 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 11 - ᠦ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠳᠣᠲᠤᠷ᠎ᠠ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ, ᠲᠠᠢᠯᠤᠨ ᠤ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠢᠶᠠᠬᠤ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮ ᠳᠦ /ᠬᠠᠶᠢᠭ/ ᠪᠠᠢᠷᠰᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ ᠲᠦ ᠦᠦᠷᠡᠭ ᠳᠠᠭᠠᠯᠭᠠᠪᠠ.

3. ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠢᠶᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠡᠷᠬᠢᠯᠡᠭᠴᠢ / ᠵ. ᠬᠠᠯᠲᠤᠷᠢᠭᠤ/ ᠳᠤ ᠳᠠᠭᠠᠯᠭᠠᠪᠠ.

ᠬᠡᠷᠡᠭ ᠡᠷᠬᠢᠯᠡᠭᠴᠢ                ᠵ. ᠪᠠᠲ

2125010001

Аймгийн Засаг даргын 2025 оны
08 дугаар сарын 09-ны өдрийн
А/406 дугаар захирамжийн хавсралт

# ТҮНШЛЭЛИЙН ТӨСӨЛД БҮРЭН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ

| | |
|---|---|
| Дарга: | |
| Б.Саранчимэг | -Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | |
| Б.Мөнгөнтуул | -Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын ахлах дотоод аудитор |
| Гишүүд: | |
| Б.Уугансүрэн | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| О.Эрдэнэтуяа | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Б.Урансүх | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| Х.Гүенбат | -Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Б.Батдорж | -Аймгийн Орон нутгийн газрын ахлах мэргэжилтэн |
| С.Урантогос | -Аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн |
| Д.Батбилэг | -Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга |
| Ж.Гантулга | -"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Дулааны шугам сүлжээний цехийн дарга |
| Б.Батболд | -"Дорнод Нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ-ын Ус дулаан дамжуулан түгээх албаны дарга |
| Д.Сүхбаатар | -Монгол Улсын зөвлөх инженер |